

МЭДЭЭ, МЭДЭЭ, МЭДЭЭ**ДЭЛХИЙН МАЛ АЖ АХУЙ**

Австрали улс 7,7 сая ам. км газар нутагтай 16,5 сая хүн амтай. Нийслэл нь Канберра. Албан ёсны хэл-англи

Австралийн хонины аж ахуй. Австралийн хонины тоо толгой 208 сая буюу дэлхийн хонины 20 % -ийг эзэлдэг. Тус орны хонины аж ахуйд манай гаригийн (миронос) ноосны чиглэлийн хонины 75 % оногдох бөгөөд дэлхийн хонины ноосон бүтээгдэхүүний 26 гаруй хувийг үйлдвэрлэдэг байна. 1989—1990 онд Австрали 6 тэрбум долларын ноос зарсан нь экспортоос орж ирдэг орлогын 20 % -ийг эзэлсэн байна. Дэлхийн ноосны зах зээлийн 60 % -ийг хангадаг энэ орон ихэнхдээ зунгагтай ноос экспортолдог боловч хааяа боловсруулсан ноос ч гаргадаг. Ийнхүү Австрали мал аж ахуй, ялангуяа хонины аж ахуйгаараа дэлхийд I байр эзэлж байна.

Японы «JETRO» ЗАХ ЗЭЭЛИЙН ХУДАЛДАА
ЦУВРАЛ НОМНООС АВАВ

МАЛАЙЗЫН ХӨГЖЛИЙН ТОЙМООС**Ч. Сувд***

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр «Азийн барууд» гэхлээр Тайвань, Гонконг, «Шинээр аж үйлдвэржсэн орнууд» гэхлээр Өмнөд Солонгос, АСЕАН гэхээр Сингапурыг төлөөлүүлэн ярьж, бусад орныг орхигдуулах явдал газар авах бололтой. Гэтэл бидэнд «толгойлох» орнуудаас дутуугүй, «бүрдүүлэх» улс орнууд ихээхэн сонирхолтой санагдана. Яагаад гэвэл манай орон хөгжлийн хүрсэн түвшин, тохиолдож буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх асуудлаараа тэдэнтэй илүү төсөөтэй. Үүнээс санаа авсан үндэсний сэргэн мандалтын үзэл баримтлал, шилэлт, сонголт, хувилбаруудаа боловсруулж болох мэт. Ингэвэл бид «алгасахын өвчинд» нэрвэгдэлгүй, суралцах, хөдөлмөрлөхийн гараанд хүрч, үнэхээрийн «дөтөлсөн» замд орох мэт. Үүнтэй уялдуулан АСЕАН-ы зургаагийн нэг болох Малайз орныг сонгон авч, түүний хөгжил дэвшлийн талаар зарим зүйлийг уншигчдын анхааралд толилуулья.

329,3 кв. км, нутаг дэвсгэртэй, 16,3 сая хүн амтай, нийслэл хот нь Каула-Лумпур бөгөөд 1 сая гаруй оршин суугчтай.

Газар зүй. Арал хойгийн энэ орон экваторын бүсийн ойролцоо орших бөгөөд хойгуураа Тайланд, урдуураа Индонезтой хил залгана. Хуурай газрынхаасаа усан хил нь хавьгүй тавиу. Далайн урин дулаан уур амьсгалтай, дунджаар 25-аас 28 хэм хүртэл дулаахан, зөвхөн уулархаг хэсэгтээ +2 хэм хүртэл сэрүү татна.

Нутаг дэвсгэрийнх нь 70 % халуун орны ой модоор бүрхмэл. Жилийн турш ногооноороо байдаг ойд нь 15 мянган төрлийн мод ургадаг.

* Ч. Сувд--Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан

Түүнээс 6 мянга нь үйлдвэрлэл, гоёл чимэглэл, эмчилгээний ач холбогдолтой. Малайз улс нь ургамлын аймгаасаа гадна ан амьтнаараа гайхагдана. 500 гаруй нэрийн шувууд, мөн сармагчин, малайзын баавгай, хоёр эвэртэй хярс, заан зэрэг ховор амьтадтай.

Малайз нь хар тугалга, нефть, байгалийн хийгээр баялаг. Дал мод, каучук, самар гэх зэргээрээ дэлхийд зартай билээ.

Хүн ам. Малайз нь хүн амын өсөлтийн түргэн хурдац, насны бүрэлдэхүүнээрээ манайхтай нэн ойролцоо. Хүн ам зүйн үүднээс үзвэл хүүхэд, залуучуудын орон юм. Наяад онд хүн амын жилийн дундаж хурдац манайх шиг 2,6 хувь байсан бөгөөд нийт хүн амд эзлэх хүүхдийн хувийн жин 40 орчим, харин манайд 44 хувь байгаа билээ. Хүн амын 80 гаруй хувь нь баруун Малайз буюу хойгийн хэсэгтээ аж төрнө. 1987 оны байдлаар Малайзын эдийн засгийн идэвхтэй хүн ам 6,2 сая, түүнээс 5,7 сая нь ажил эрхэлж байв. Хөдөө аж ахуйд 2 сая (35,3 %), боловсруулах үйлдвэрт 820,0 мянга (14,4 %), уул уурхайд 52,5 мянга (0,9 %), барилгад 370,0 мянга (6,5 %), тээвэр, холбоо, эрчим хүч, усан хангамжинд 30,0 мянга (5,0%), засаг захиргаанд 850,0 мянга (14,5%), эдийн засгийн бусад салбарт 1,3 сая буюу 23,0% нь ажиллаж байна. Гэлээ ч гэсэн Малайзид хөдөлмөрийн нөөцийн өсөлт, ажлын байрны өсөлтөөс түрүүлсэн учир ажилгүйдлийн түвшин 5,3-аас 8—10 хувьд хүрчээ.¹

Малайз бол угсаа гарлаараа олон үндэстний улс юм. Хамгийн олон хүнтэй угсаатны бүлэг бол малай, хятад бөгөөд тэд өөрсдийн соёл, шашин, хэл, заншлаараа сүрхий ялгарна. Баруун Малайзид малайзчуудын 57,6% нь амьдарч байхад хятадууд Маллакийн хойгийн Сабаха, Сараваха хотод бөөгнөрч, Энэтхэг, Шри-Ланкаас гаралтай хүмүүс нь хот, хөдөөгүй жигдхэн, харин нутгийн уугуул иргэд-үндэстний цөөнх Тайландтай залгаа нутагт аж төрөх жишээтэй.

Малайзын албан ёсны хэл нь малайз, гэвч өдөр тутмын амьдралд янз бүрийн ястан, угсаатны хэл, аялгуунууд зэрэгцэн орших учир ажил төрөлдөө англи хэлийг нийтлэг хэрэглэнэ.

Шашин шүтлэг. Малайзын албан ёсны шашин нь ислам боловч үндэстэн, ястны шашин шүтлэг харьцангуй эрх чөлөөтэй. Сүм хийдүүд үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулна. Малайзууд бүгдээрээ, хятад энэтхэгчүүдийн хагас нь лал, хятадуудын дийлэнх нь будда, болон дао энэтхэгчүүдийн ихэнх индуизм, цөөнх нь будда, харин хятад, энэтхэг, европ гаралтай зарим хүмүүс нь загалмайтны шашин шүтэж биширдэг ажээ.

Боловсрол. Наяад оны байдлаар хүн амын 30 шахам хувь нь бичиг үсэг мэдэхгүй байсан бол сүүлийн жилүүдэд гэгээрэл, боловсролын салбарт мэдэгдэхүйц амжилт олж байна. Англи, Хятад, тамиль хэлээр анхан шатны (6 жил суралцана), малайз хэлээр дунд боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Дунд боловсрол нь хоёр шаттай. Эхний шатанд 3 жил суралцаж, тодорхой мэргэжлийн чиг баримжаатай болж бүрэн бус дунд боловсрол эзэмшдэг бол дараагийн шатанд хоёр жил суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшинэ. Энэхүү боловсролыг олсон хүмүүс нь нэг бол улс ардын аж ахуйд нарийн мэргэжлийн боловсон хүчнээр ажиллах, эсвэл аж үйлдвэр, хөдөө аж ахуйн коллежид элсэх сурагчдад багшлах чадвартай байна. Тус орон 5 их сургууль, хэд хэдэн коллеж, дээд сургуультай.

Төр засгийн байгууламж. Малайзын холбоо нь 13 муж, холбооны нутаг дэвсгэрээс бүрэлдэх бөгөөд 9 мужийг нь үе залгамжлан захирдаг бол дөрвийнх нь ерөнхий сайдыг төрийн тэргүүн томилно. Ерөнхийдөө Малайз нь өвөрмөц онцлог бүхий Үндсэн хуульт хаант засагтай оронд багтана. Эрх баригч султануудыг бага хурлаар, төрийн тэргүүн хааныг

5 жилийн хугацаагаар сонгоно. Ийнхүү холбооны систем нь хаант засгийн хуучинсаг төрхийг хамгаална. Тус улс үндсэн хуулиндаа үндэстэн ястны зан заншил, хэл соёл, шашин шүтлэгийг ч, мөн түүнчлэн уугуул хүн амын иргэний онцгой эрх дарх, ямбыг хуульчлан хамгаалсан байдаг. Хууль тогтоох байгууллага нь 5 жилийн хугацаагаар сонгогдсон сенатын хийгээд тэнхимийн гишүүдээс бүрэлдсэн парламент болно. Гүйцэтгэн захирах дээд засаглал нь ерөнхий сайд бөгөөд холбооны нутаг дэвсгэрийг төрөлжсөн яамд удирдана. Малайз нь олон намын системтэй бөгөөд Малайзын үндэсний нэгдсэн байгууллага, Малайзын хятадын холбоо, Малайзын энэтхэгийн конгресс, Лалын нам, Ардчилсан хөдөлгөөний нам зэрэг эрх баригч хийгээд сөрөг нам, улс төржсөн хөдөлгөөнүүд бий.

Эдийн засаг. Малайзын нийгмийн амьдралын бүх хүрээний дотроос нарийвчлан судлууштай нь тус орны аж ахуйн бүтэц, хөгжлийн хурдац, цар хэмжээ, туршлага сургамж билээ. Шинээр аж үйлдвэржсэн 8 орны 4-ийг зүүн Азийн (Тайвань, Гонконг, БНСУ, Сингапур) нөгөө 4-ийг зүүн өмнөд Азийн (Индонез, Малайз, Тайланд Филиппин) орнууд гэх бөгөөд эхнийх нь хөгжлийн төвшингөөрөө дээгүүр юм. Тэгвэл тэдэнд хамгийн ойрхон яваа нь Малайз. 1988 оны байдлаар нэг хүнд ногдох нийгмийн нийт бүтээгдэхүүн Малайзид 1870 доллар байв. Энэ нь эхний дөрвийнхөөс (Гонконг-9230, Сингапур-9100, Тайланд -6030, Өмнөд Солонгос-3530) доогуур ч гэсэн нөгөө гурваасаа (Тайланд 1000, Филиппин 630, Индонез 430) хамаагүй ахиу юм.² Малайзын нийгмийн нийт бүтээгдэхүүний жилийн дундаж хурдац наяд оныхоосоо (1971—1980 онд 8,0) саарсан ч өнөө хэр нь өндөр хэвээр байна. Тухайлбал, 1988 онд 8,7, 1989 онд 7,6, 1990 онд 7,9 % байв.³

Малайзын эдийн засгийн хөгжлийн ололт амжилтын нэгэн илэрхийлэл нь түүний салбарын бүтцийн өөрчлөлт юм. Жишээлбэл, 1970 онд тус орны нийгмийн бүтээгдэхүүний 30,0% нь хөдөө аж ахуйд, 22,9% нь аж үйлдвэрт, 43,3% нь үйлчилгээний салбарт ногдож байсан бол 1989 онд харьцуулах үзүүлэлт 20,2; 41,0; 38,7 нэгж болж⁴, аж үйлдвэрийн хувийн жин мэдэгдэхүйц нэмэгдэв.

Малайзын эдийн засгийн амьдралыг дараах үзүүлэлтүүдээр илэрхийлбэл:

Нийгмийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь ⁵	1981	1985	1988	1989	1990
Нийт хадгаламжийн норм	28,8	32,5	36,4	33,5	31,4
Нийт хуримтлалын норм	35,0	27,6	26,1	27,9	27,0
Экспортын квот	46,1	48,5	60,1	68,1	-
Импортын квот	41,7	37,0	44,1	56,4	-

Малайзын эдийн засгийн хөгжлийг товч атугай ч харуулахдаа түүний 5 жилийн төлөвлөгөөтэй хөгждөг онцлогийг дурьдалгүй өнгөрч болохгүй. Малайзын нийгмийг өөрчлөх чиг шугам буюу «Шинэ эдийн засгийн бодлого» нь даруй 5 жилийн нүүр үзэж байна. 1971—1975 оны II таван жилийн төлөвлөгөөний гол зорилт нь үйлдвэрлэх хүчний жигд бус байдлыг даван туулах, ядуурлыг арилгах, угсаатан ястнуудын хөгжлийн төвшингийн ялгааг багасгахад чиглэгдэж байсан. 1975-1980 оных (III таван жил) өөрийн нөөцөд тулгуурлан «хувийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн, ард түмний амьжиргааг сайжруулах», 1981 — 1985 оных Малайзын хүн амыг аж ахуйн үйл ажиллагаанд түргэн татан оруулах, дэлхийн зах зээлийн эргэлтийн хэлбэлзлээс хамгаалагдсан хөгжингүй бо-

повсруулах аж үйлдвэртэй олон салбарт аж ахуйг бүтээн босгох, батлан хамгаалах үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэсэн гурван зорилтоос бүтэж байлаа. Харин V таван жилийнх нь тогтвортой байдлыг хангаж, алгуурхан хөгжих явдал байв. Малайзын улс ардын аж ахуйн хөгжилд зориулан II таван жилд 9,8 тэрбум, III таван жилд 32,0 тэрбум, IV таван жилд 39,0 тэрбум рингийн (үндэсний валют) хөрөнгө оруулжээ. V таван жилд хөрөнгө оруулалтыг 2 дахин нэмэгдүүлэхээр дэврүүндүү төлөвлөсөн ч 49,0 тэрбум рингийн хөрөнгө оруулалт хийгээд байна.

Хөдөө аж ахуй. Малайзын хөдөө аж ахуй нь том газар эзэмшил, улсын тарианы онцгой сан, хувийн аж ахуйнаас бүрэлдэнэ. Каучук, далдуу модны толин тариалалт, экспортоор дэлхийд дээгүүр ордог. Мөн какаогоор дэлхийд IV байр эзэлж, 15 мянган т перец хураан авч байв. Малайз нь техникийн болон хүнсний зарим ургамлаараа нэрд гарсан ч цагаан будаагаар дотоод хэрэгцээний 3/4-г хангаж, ихээхэн хэмжээний хүнсний зүйл гадаадаас худалдан авсаар байна.

Аж үйлдвэр. Наяад оноос малайзын аж үйлдвэрт бүтцийн өөрчлөлт гарч, хөнгөн аж үйлдвэрээс боловсруулах аж үйлдвэр зонхилох шинжийг олов. Хар тугалганы нөөц хомсдож, экспорт нь 1/3-ээр багассан ч гэсэн түүгээрээ дэлхийд тэргүүн байр эзэлсээр байна. Нефтийн нөөц нь 500 сая т. байгалийн хийнийх 1400 тэрбум шоо метрээр үнэлэгдэж байна. 1987 онд 16 тэрбум шоо м хий олборложээ. 1987 оны байдлаар тус улсын түлш эрчим хүчний үйлдвэрлэлийн хэрэглээний тэнцэлд нефть 89,0, усны нөөц 7,0, хий 4,0-хон хувийг эзэлж байгааг үндсээр нь өөрчилж, энэ зууны сүүл гэхэд нефтийг 40 хүртэл хувьд буулгаж, хий болон усныхыг дор бүр нь 30 хувьд хүргэхийг зорьж байна.

Тээвэр холбоо. Малайзын тээвэрт далайн тээвэр онцгой байр эзлэх бөгөөд 2,8 сая т багтаамж бүхий 354 хөлөг онгоцтой юм. Мөн авто аж ахуй нь 3,2 сая тээврийн хэрэгсэлтэй, үүнээс 320000 ачааны, 20000 автобус, 1,2 сая хөнгөн тэрэгтэй. Авто замын урт нь 39,4 мянган км. Үүнээс 26,4 хувь нь хатуу хучилттай. Онцгой ач холбогдол бүхий 13,6 км урт гүүртэй. Төмөр замын урт нь 1660 км. Орчин үеийн 40 онгоц бүхий «Малэйшин Эйрланз систем» хэмээх нисэхийн компани нь дотоодын 36, гадаадын 23 чиглэлд нислэг хийж байна. Мөн олон улсын нисэх онгоцны 4 том буудалтай. Малайзын 100 өрхийн 8,9 нь утастай. 282 станц нь бараг цөмөөрөө автомат горимоор ажилладаг, «Номхон далай» хэмээх сансрын холбоонд хамрагджээ. Мөн тэрчлэн дүрсний телефон ирмүүн хөгжиж байна.

Гадаад худалдаа. Малайзын барааны экспорт гэхэд 1981 онд 11,6; 1985 онд 15,1; 1990 онд 28,0 тэрбум доллар, харин энэ онд 33,2 тэрбум долларт хүрэх төлөвтэй. Гадаад худалдааны эргэлтийн 1/5 нь Японд, 18% нь АНУ-д 17% нь Сингапурт, 14—15 % нь нийтийн зах зээлийн орнуудад ногдож байна.

Санхүү, зээл. Малайзын улсын төсөв нь жилээр төлөвлөгддөг. 1987 оны байдлаар төсвийн нийт орлого нь 18,4 тэрбум ринг, харин алдагдал нь 3,4 тэрбум ринг байв. Хөгжлийн төсвийн орлого нь ердөө 1,1, зарлага нь 6,7, төлөвлөгөөт алдагдал нь 5,6 тэрбум ринг байгаа нь нэг талаас татварын бодлоготой, нөгөө талаас эдийн засгийн ерөнхий бэрхшээлтэй холбоотой юм. Үүний тод илрэл бол гадаад өрийн өсөлт юм. Малайз нь гадаадад 1981 онд 9,2, 1985 онд 20,4, 1990 онд 19,0 тэрбум долларын өртэй байв. Өр зээлийн хувьд Малайз 54,1 тэрбум долларын өртэй Индонез, 30 тэрбум долларын өртэй Тайланд, Филиппинг бодвол бага, огт өргүй Гонконг, Тайваныг бодвол их. Тэгэхдээ өр зээлийн хэмжээндээ бус, харин өр төлбөрт унах механизмдаа хэргийн учир байдаг. Тэгвэл энэ жил Малайзын гадаад өр ихсэхгүй, харин нэг тэрбуман доллараар хорогдох төлөвтэйг цохон дурьдалтай.

Аялал, жуулчлал. АСЕАН-ы орнуудын нэн ялангуяа Малайзын хөгжлийн нэгэн содон онцлог бол аялал жуулчлалын шинэхэн салбарыг ирмүүхэн хөгжүүлж буй явдал мөн. Урин дулаан уур амьсгал, байгалийн үзэмж, түүх соёлын өв сандаа дулдуйдан олон улсын аялал жуулчлал хөгжүүлж, үүнийг дагалдан зочид буудлын барилгажилт, үйлчилгээний иж салбар хурдан нэмэгдэж байна. Энэ утгаар нь Малайзыг аж үйлдвэржүүлэлтийг «алгасан», хөдөө аж ахуйн орноос шууд үйлчилгээний орон боллоо гэж онцолдог тал бий.

Малайз нь АСЕАН-ы бусад орнуудтай харьцуулбал хөгжлийн нийгмийн асуудалд илүү анхаардаг. Тийм учир эдийн засагт эзлэх улсын секторын хувийн жин өндөр юм. Засгийн газар улсын янз бүрийн байгууллагуудаар дамжуулан банк, үйлдвэр нийгмийн дэд бүтэц, дал модны тариалангийн газар, телевиз, усан буудлыг хяналтандаа байлгадаг Малайзын экспорт түүхий эдийн шинжтэй, тэгээд ч нефть, хар тугалга, дал модны тосны дэлхийн зах зээлийн онцлог зэрэг нь улсын сектор зонхилох нөхцөл бүрдүүлж байна.

1985 онд английн эдийн засагчид, санхүүгийн шинжээч нарыг идэвхтэй оролцуулан Өмч хувьчлах хөтөлбөрийг боловсруулан батлав. Санхүүгийн бус 900 гаруй корпорацийг хувьчлах чиглэл барьж буй боловч «эдийн засгийн шинэ бодлого»-ыг баримтлагсад өмчийн хэлбэрийг өөрчлөлгүй, харин улсын үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэхийг нэлээд чухалчилж байна. 1983 онд теле нэвтрүүлгийн 1 сувгийг, 1985 онд сугалааг, улсын агаарын тээврийн компаний хувьцааны 30%, 1988 онд дахин 40%-ийг хувьд өгчээ. 1986 онд 3,4 тэрбум долларын өртөг бүхий автозамыг улсын болон хувийн пүүсүүд хамтран барьж 25 жилийн дараа өмчийг засгийн газарт шилжүүлэх юм.

Өмч хувьчлах ажил эдийн засгийг хөгжүүлэх өнөөгийн хөтөлбөрийг дуусгаж, 90-ээд онд аж ахуйн үйл ажиллагааг либералчлахыг онцлон буй шинэ бодлогод шилжсэнтэй уялдан хурдасч ирэх юм. Ингэснээр засгийн газраас үзүүлдэг нөлөөг сулруулж, хөрөнгө их шаарддаг ган хайлуулалт, хими, машины үйлдвэрт улсын бус салбарын хөрөнгө оруулалтыг татан оруулахыг хөхүүлэн дэмжих болно. Хувьчлалын үр дүнд 1,4 тэрбум долларын хэмнэлт гарч, цаашилбал улсын 4 том компанийг хувьчилснаар гадаад өрийг 2,8 тэрбум доллараар нимгэлэх тооцоо ч бий

Малайзын хөгжлийн тоймд тулгуурлан доорх санал дүгнэлт хийж болохоор байна. Үүнд: 1-рт, Малайз нь улс төрийн тогтолцоондоо уламжлал, тэр битгий хэл хуучинсаг зүйлсийг хадгалан үлдээсэн хэрнээ, эдийн засгийн бодлогодоо шинэчлэлийн үзэл санааг тууштай баримтлан, улс орныхоо онцлог, давуу талд тулгуурлан хөгжиж буйн ачаар шинээр аж үйлдвэржиж яваа орны хэр зэргэмжид хүрчээ. 2-рт, хөдөө аж ахуй зонхилсон, нэгэн салбарт өрөөсгөл эдийн засгийг дэвжээн хөгжүүлж, орчин үеийн олон салбарт, төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг бүрэлдүүлж эхэлжээ. Тэгэхдээ манайх шиг хөдөө аж ахуйгаа тамирдуулах замаар бус, харин түүндээ тулгуурлаж, орчин үеийн тооцоолон бодох машиныг оролцуулсан, шинжлэх ухааны багтаамжтай аж үйлдвэр, тэрчлэн тээвэр холбооны найдвартай сүлжил бүхий дэд бүтэц, аялал жуулчлалын салбарыг хүртэл хөгжүүлжээ. 3-рт, хувийн жижиг, дунд үйлдвэр хийгээд экспортыг баримжаалсан үйлдвэр хөгжүүлсний ачаар эдийн засгийн бүтцэд гүнзгий өөрчлөлт гарчээ. Мөн гадаадын хөрөнгө оруулалт ихсэв. 4-рт, эдийн засгийн төвлөрөл, хувьчлалыг зохистой хослон гадаад өрийн дарамтыг саармагжуулж, улмаар багасгах төлөвийг олжээ.

1. Юго-Восточная Азия. Несоциалистические страны. М. 1989 263 дахь тал
2. Азия и Африка сегодня 1991 № 1, 40—43 дахь тал.
- 3./4./5. Мөн тэнд